

**ТУСГААР ТОГТНОЛОО ДАХИН СЭРГЭЭСЭН МОНГОЛ
УЛСЫН ТАЛААР АНУ-ЫН БАРИМТАЛЖ
БАЙСАН БАЙР СУУРЬ
/1911-1915/**

Т.Төмөрхүлэг. Монгол Улсын Их Сургууль

Өгүүллийн точ утга: 1911-1915 онд АНУ-ын засгийн газрын Монголын талаар баримталж байсан байр суурь нь бусад их гүрнүүдийнхтэй ерөнхийдөө нийцэж байсан боловч, цаашдаа Орос, Хятадын хооронд яггүй зөрчил гарахын шалтаг болох учиртай хэмээн үзэж уул асуудлыг шийдвэрлэлгүй орхиход оршиж байжээ.
Түлхүүр үг: Монгол –АНУ, Орос, Хятад-АНУ

1911 оны эцсээр Гадаад Монгол тусгаар тогтнолоо зарласан хийгээд 1912 онд Хаант Орос Монголтой хэлэлцээр байгуулсан нь Америкийн Нэгдсэн улсын улс төрийн болоод худалдаа наймааны хүрээнийхний сэтгэлийг баахан түгшээсэн ажээ. 1911 оны 12 дугаар сард Францын “Матэн” сонин Нью-Йоркоос Монголын тухай мэдээ хүлээж авчээ. Уг мэдээнд өгүүлэхдээ: “ Орос, Япон хоёр Алс Дорнодод нөлөөнийхөө хүрээг тодорхойлох зорилгоор хэлэлцэн тогтлоо. Чингэснээр Америкийн төлөвлөгөөг нурааж, “нээлттэй хаалгын бодлого” үлгэр домог болох юм ¹ гэж энд үзэж байна” гэжээ. Орос улс Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нь эцсийн бүлэгт тус орныг өөртөө нэгтгэж авахад хүргэнэ гэж тэр үеэр Америкийн сонинуудад бичиж байжээ. Нөгөөтэйгүүр, эдгээр сонинуудад, манжуурын төмөр замын гэх зэрэг асуудлаар зохисгүй санал оруулсан холбооны засгийн газрынхаа үйл ажлыг мэдээлэхийн ялдар америкчууд өөрсдөө Орос, Япон хоёрын ойртоход дэм үзүүлчихсэн юм гэж харамсан өгүүлжээ. Хэвлэл сонинууд нь давын түрүүнд Орос-Монголын хэлэлцээрийн гол гол зүйлүүд болон америкийн үзэл бодлын үүднээс үүсэн гарч буй үр дагаварт олон түмний анхаарлыг хандуулсан байна.

“Нью-Йорк таймс” сонины 1912 оны 12 дугаарын дугаарт Санкт-Петербург хотод сууж байсан сурвалжлагчийн бичсэн өгүүлэлд Орос-Монголын байгуулсан хэлэлцээрийн хамгийн чухал гэсэн заалтуудыг товч дүгнэхийн сацуу Орос, Хятадын тухайд Монголчууд шинэ байдал үүсгэснийг дурдаад, үүнээс шалтгаалж Америкийн эрх ашиг хэрхэн хөндөгдөхийг заажээ. Энэхүү сурвалжлагч, уг хэлэлцээрээс үүдэн аяндаа гарч ирэх үр дагавраас болон Япон улсын Өмнөд Манжуур хийгээд Монголд хийхээр завдаж буй үйлдлээс шалтгаалж, Америкийн

¹ Matin, 29 décembre 1911.

эрх ашиг хөндөгдөнө, байдал цаашдаа улам хүндрэнэ² гэсэн байна. “Нью-Йорк Херальд” сонин Бээжинд ажиллаж байсан сурвалжлагчийнхаа Хятадын зэвсэгт хүчний ажиллагааны талаархи мэдээлийг нийтлэж, үүгээрээ Монголыг номхотгож өгнө гэж найдлага тасраагүйгээ илэрхийлжээ³. Энэ тухай Вашингтонд сууж Францын элчин сайд төвдөө мэдээлсэн юм.

АНУ-тай дипломат харилцаа тогтоох гэж Монголын засгийн газрын 1912 онд илгээсэн анхны захидлыг Төрийн департаментад Алс дорнодын хэргийг эрхэлсэн тасгийн дарга Рэнсфорд С.Миллер хүлээн аваад төрийн нарийн бичгийн даргадаа бичиж явуулсан нууц ноот бичиг байдаг аж. Миллер ноёнтон “манай сенатч нарт бас нэг асуудал гараад ирлээ”⁴ гэж уул ноотдоо дурджээ. Монголын асуудлыг Сенатад лав хэлэлцэнэ гэж Миллер авгай бодож байсан хэрэг бололтой.

Бээжинд сууж байсан Германы элчин сайд Монголд үүссэн шинэ нөхцөл байдлын талаар Америкийн засгийн газрын байр суурийг тандах үүргийг Гадаад хэргийн Яамнаасаа авсан байжээ. АНУ Монголын ноос ноолуурыг Тяньзинээр экспортолдог гол худалдан авагч агаад нэхмэл эдлэл, үр тариа зэргийг нийлүүлэхэд голлон оролцдог тул Монгол дахь Оросын онцгой ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх замаар өмнөх гэрээ хэлэлцээрүүдийг нь Америкт хохирол учруулахуйцаар өөрчлүүлэхгүй байлгах эрмэлзэлтэй байх учиртай гэж Берлинд үзэж байсан юмсанжээ⁵.

1916 оны 3 дугаар сард Их Хүрээнд ирсэн Америкийн “Андерсен, Мейер К⁰” компаний эзэн Мейер Оросын консулд америкчууд Хаалганд хивсний үйлдвэр барих бодолтойг мэдээлж, үүний тулд Гадаад Монголоос үлэмжхэн хэмжээний ноос худалдан авах, нөгөөтэйгүүр, Өвөр Монголд меринос үүдрийн хонь авчирч нутгийн үүлдрийг сайжруулан хонины аж ахуй өргөн хэмжээнд эрхлэх хүсэлтэйгээ хэлжээ⁶. Чингэхээр Монголын ноос ноолуурыг тэр үед ихэвчлэн Америк, Их Британи урьдын адил гадагш гаргаж байсан нь илэрхий. Энэ фирм өөр нэгэн төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан нь гэвэл Хаалган, Өргөө хот хоёрын хоорондахь урт замд тохилог өртөөнүүдтэй харилцаа холбооны үйлчилгээ буй болгох явдал байсан юм.

² New-York Times, December 1, 1912.

³ Archive du MAE de la France, N.S. Pays : Chine, № du volume 80, pp. 2-3.

⁴ Underdown M. Aspects of Mongolian History, 1901-1915, p.181.

⁵ Die Grosse Politik, bd.32, №12002, s.439-440

⁶ “Международны отношения в эпоху империализма”, серия III, т. VII, ч. I, стр. 404-405.

“Пекин Дейли Ньюс” сонины мэдээлснээр, Бээжинд сууж байсан АНУ-ын элчин сайд Юань-Шикайд, өөрийнхөө засгийн газрыг Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг мэдэгдэж байжээ⁷. Төрийн нарийн бичгийн дарга Ноксийн ярьж байснаас үзвэл, Америкийн засгийн газар 1912 оны Орос-Монголын хэлэлцээрийн талаар Хаант Оросын засгийн газрын мэдэгдлийг хоёр нүүр гаргасан баримт бичиг гэж үзжээ⁸. Ерөнхийдөө, Америкийн засгийн газар Оросын засгийн газарт таагүй хандаж байсан бөгөөд Бээжинд сууж байсан Оросын төлөөлөгчид Америк Хятадад зээл олгох нь Монгол, Манжуур зэрэг нутагт Хятадын явуулж буй бодлогыг өөгшүүлэхэд хүргэнэ гэж аль болохоор саад тотгор учруулахыг оролдож байжээ.

1913 оны эхээр Нокс Германы элчин сайд Бернсторфт мэдэгдэхдээ, Орос-Монголын хэлэлцээрийн хавсралт протоколыг өөрийнхөө орны хувьд тааламжгүй хэмээн мэдэгдсэн байна⁹. Чингэхдээ, Монголд онцгой ажиллагаа эрхлэхийг нь хорьчихлоо хэмээн халаглаж байжээ. Түүний бодлоор бол, үүнээс яаж гарах вэ гэвэл америкийн шаардлагыг хятадын асуудлаар Петербургээс тавьж болох шаардлагатай уялдуулах замаар Орост дарамт үзүүлэх явдал юм гэжээ¹⁰.

Түүнээс гадна, энэ үед дипломатуудын хүрээнд монголын асуудлаар АНУ, Герман адил байр суурь баримталж байна гэсэн яриа тархжээ. Үүнийг 1913 оны эцсээр Оросын Гадаад Яамны сайд Сазоновоос Сангийн Яамны сайд Коковцовд илгээсэн захидлаас үзэж болно. Эл захидалд өгүүлэхдээ, “Япон, Франц, Их Британий засгийн газрууд манайхтай харилцахдаа [бидний] Гадаад Монгол дахь давуу байдлыг хоёрдмол санаагүйгээр хүлээн зөвшөөрсөн. Эдгээр улсын засгийн газрууд дэмжих болов уу, яах бол гэж эмээх явдалгүй... Хэдий тийм боловч, Герман болоод Америкийн засгийн газруудын тухайд тэгж үзэж болохгүй”¹¹ гэжээ. Түүнчлэн, 1912 оны 1 дүгээр сард Германы Гадаад хэргийн сайд Зиммерман Францын элчин сайд Жюль Камбонд ярихдаа, монголын асуудлаар АНУ, Герман хоёр адил ашиг сонирхолтой гэжээ¹². Энэ шалтгаанаар хятадууд олон улсын талбарт Оросын засгийн газарт дарамт үзүүлэхэд юуны түрүүнд АНУ, Германд найдлага тавьж байжээ. Энэ ч учраас Юань-Шикай монголын асуудлыг

⁷ Ширендыб. История Монгольской народной революции. Сокр. Перевод с монг. –М., 1971, стр. 43.

⁸ Die Grosse Politik, bd. 32, № 11997, s.434.

⁹ Ibid.

¹⁰ Ibid

¹¹ “Международные отношения...”, серия III, т.I, стр.15.

¹² Documents diplomatiques français, Troisième série, t.I, p. 514.

хөндлөнгийн шүүх юм уу Европын их гүрнүүдийн бага хурлын хүрээнд хэлэлцүүлвэл ямар вэ гэж эдгээр улсын засгийн газарт санаа авахуулж байсан¹² аж.

Эдгээр баримтыг ерөнхийд нь авч үзэх юм бол Монголын талаар америкийн хэвлэл ямар ч атугай засгийн газрынхаа байр суурийг аль нэг хэмжээгээр ойролцоо тусгаж байжээ гэж дүгнэн үзэж болох юм.

Тийн авч монголын асуудлаар Америкийн албаны хүмүүсийн Оросын дипломатуудад ярьж байсан зүйл албан ёсных нь байр сууриас баахан зөрүүтэй байдаг нь сонирхол татдаг. Бээжинд сууж байсан америкийн элчин 1912 оны 4 дүгээр сард Оросын түр хамаарагчид Монголтой холбогдуулан, "Вашингтоноос хүлээн авсан зааварчилгаанд нь Монгол, Манжуур дахь Оросын үйл ажиллагаанд саад хийхийг өдөөсөн юу ч байхгүй, тэр тусмаа үүнийг тандан судлах тухай зүйл ч үгүй"¹³ гэж их л шийдвэр төгс өгүүлсэн бий. Өөр нэгэн жишээ хэлбэл, урьд өмнө Бээжинд элчин, Санкт-Петербургт элчин сайдаар ажиллаж байсан, хятадач, төвд хэлний мэдлэгтэй, Юань-Шикайн найз Х.Рокхилл 1913 оны 12 дугаар сард Өргөө хотод ирээд Монголын томоохон албаны хүмүүстэй уулзахдаа, Гадаад Монголын цаашдаа цэцэглэн хөгжихийн баталгаа нь Орост чин үнэнчээр итгэж, зөвлөгөө сургамжийг нь хэлбэрэлтгүй дагах л мөн шүү гэжээ¹⁴. Рокхилл ноёнтон Дотоод яамны сайд Цэрэнчимэдтэй ярилцахдаа, монголчууд Оросын үнэн сэтгэлийн өгөөмөр зуучлалд хязгааргүй талархах ёстой, агуу их хөршийнхөө Өргөөд суугаа төлөөлчидтэй урьдаас зөвлөлдөлдөггүйгээр юуг ч зүрхлэн бүү хийгтүн¹⁵ гэж онцлон ярьжээ. Чингэхэд, энэ бүх яриа Оросын Консулын газрын хэлмэрчийн туслалцаатай болсон аж. Оросын дипломат төлөөлөгч Гадаад яамандаа бичихдээ, Рокхилл ноёнтон засгийн газрынхаа тусгай даалгаврыг биелүүлэхээр ийнхүү урт аялал хийж яваа мэт сэтгэгдэл төрлөө¹⁶ гэжээ.

Ийнхүү, дээр өгүүлснээр, монголын асуудлаар америкчуудын аман яриа, албан ёсны байр суурийнх нь хооронд зөрөөтэй зүйл ажиглагдсаныг нарийвчлан шинжлүүштэй юм. Америкийн засгийн газар монголын талаар Орос, Японы бодлогод өшөөрхөн ханддаг атал томоохон дипломат нь Оросыг ямагт

¹² "Минь-ли бао", № 906, 1913 г. В жур. : Дальний Восток, № 21, 25 мая 1913 г. – Иркутск, 1913, стр. 1-2.

¹³ "Международные отношения...", т. XX, ч. I, стр. 4.

¹⁴ Царская Россия и Монголия в 1913-1914 гг., « Красный Архив », 1929, т. VI, стр. 44-45.

¹⁵ Там же.

¹⁶ Там же.

хэлбэрэлтгүйгээр дагаад бай гэж монголчуудад зөвлөсөн гэхэд одоо ч гайхаж болох юм. Рокхиллийн санал бодол ч зөрчилтэй мэт. Юу вэ гэвэл, яриандаа тэр, Монгол дахь Оросын үйл ажиллагааг сайшааж, япончуудыг тааруухнаар хэлсэн атлаа Гадаад Монгол, Дотоод Монгол хоёрыг соёлын түвшний хувьд ялгаатай тул нэгдэх тухай яриа байж таарахгүй гэжээ. Рокхиллийн ярианы бас нэг эргэлзээтэй тал гэвэл, Цэрэнчимидийг яаруу шийдвэр гаргахаас болгоомжлохыг ятгахдаа, “Муж байж байгаад шууд бие даасан улс болж чаддаггүй юм”¹⁷ гэж тайлбарлажээ. За яах вэ, Рокхиллийн энэ баримтлалыг тухайн үеийн хүний хувийн санаа бодол гэж үзье. Үнэндээ ийм үзэл бодол түүхийн шалгуурыг даасангүй. XX зууны дунд үеэс их гүрнүүдийн колони байсан Ази, Африкийн олон үндэстэн ахар богино хугацаанд тусгаар тогтносон улс гүрэн болсноор энэ үзэл санаа түүхийн хог дээр хаягджээ.

Америкийн улс төрийн утга зохиолд Рокхиллийн Өргөө хотод айлчилсныг улс төрийн аль нэгэн төлөөлөлтэй ямар ч учир холбогдолгүй гэж бичсээр ирсэн аж. Юу вэ гэвэл Рокхилл өөрөө Өргөөгөөс буцаж очоод хэдэн сар болсныхоо дараа өгсөн ярилцлагадаа энэ тухай мэдэгдсэн юм. Гэтэл, түүний ярилцлага бодот баримтаар үнэнтэй хараахан нийцэхгүй нь илэрхий болов.

Үүнийг бичигч 1985 онд Францын Гадаад хэргийн Яамны архивд Монголын талаар Америкийн байр суурьтай холбогдох хоёр баримт бичиг үзсэн билээ. Үүнд, нэгдэх нь тэр үед Юань-Шикайн гадаад бодлогын зөвлөгч байсан доктор Морриссоны бичиг¹⁸, нөгөөдөх нь Бээжинд сууж байсан Дипломат төлөөлөгчийн газар дахь цэргийн атташе хошууч Колладегийн мэдээлснээр “Бээжинд АНУ-ын өлчингээр, үүний урьд Петербургт элчин сайдаар тус тус сууж байсан Рокхиллийн бичсэн баримт бичиг”¹⁹ бүлгээ. Зохиогчид, Орос-Хятад хоёр улсын Монголын талаархи 1913 оны Тунхаглалын дараа бичсэн дээрхи бүтээлүүддээ, тэр үеийн Монголд буй болсон нөхцөл байдлын цаад учир шалтгаан, үүссэн бэрхшээл зэргийг хөндөөд дараахь дүгнэлт гаргажээ: “Нэг талаар, хятадууд нөгөө л сурсан зангаараа өөрсдийнхөө хүчин чадлыг хэтийдүүлэн үнэлж, цаг нь ирээгүй байхад монголчуудын эсэргүүцлийг өдөөн, улс төрийн цөмрөлт болон ихэрхүү санаагаараа оросуудад төвөг удсан юм. Нөгөөтэйгүүр, орос, монголчууд Хятадын

¹⁷ Царская Россия и Монголия в 1913-1914 гг., “Красный архив”, 1929, т.VI, стр. 44-45.

¹⁸ Сладковский М.И. Китай и Англия. —М., 1980, стр. 132.

¹⁹ Archive du MAE de la France. N.S. Pays : Chine, № du volume 80, p.216.

хүчин чадлыг дэндүү дээгүүр тавьж, хамгаалах байр суурьнаас хандсан бөгөөд нэгэнт үүссэн нөхцөл байдлаас өөрсөддөө ашиг унагааж чадсангүй”²⁰ гэжээ. Цааш өгүүлсэн нь: “Оросууд, Өвөр Монголд япончуудыг нэвтрүүлэх үүднээс дипломат үйл ажиллагаагаараа аядуу зөөлөн хандлага үзүүлж, золиос хаяснаараа Орос, Японы хооронд дахин мөргөлдөөн үүсгэхүйц илэрхий шалтгыг арилгав. Чингэхдээ, өрсөлдөгч этгээддээ Таонанфу-Кириний чиглэлд хүчээ зузаатган дайны талбараа өргөтгөх боломж олгоод, Төвдөөс Манжуур хүртэл шарын шажинтны томоохон улс байгуулах замаар алс хэтдээ холбоотонтой болох санаархлаа огоороход хүрэв. Тийн авч Орос улс умард болон баруун чиглэлд хятадуудын нэвтрэхийг зогсоон тун ч хойшлуулшгүй хэргийг цэглэж чадав. **Орос, хятад, япончуудын хооронд нөлөөний хүрээний төлөө тэмцэл нууцхан үргэлжлэх** бөгөөд Хятадад шинээр хийж буй цэрэг дайны бэлтгэл ажил [улс төрийн] газрын зургийг өөрчлөх олон тохиолдлыг үүдэх нь эргэлзээгүй”²¹.

Үүнээс үзэх юм бол 1913 онд Орос, Хятад хоёр Гадаад Монголын асуудлаар хэлэлцэн тогтсоны дараа АНУ-ын Төрийн департамент алс хэтийнхээ оньч /стратегийн/ бодлогын үүднээс монголын асуудалд арай өөрөөр хандах болсон байна гэж үзэлтэй. Энэ ч зорилгоор 1913 оны 12 дугаар сарын тэсгим хүйтнээр Орос, Хятадаар мэргэшсэн Рокхилл ноёнтонг Нийслэл хүрээ рүү илгээсэн бололтой.

Нэр бүхий хоёр судлаачийн дүгнэлтээс юуг харж болох вэ гэвэл америкчууд ямар ч атугай монголын асуудлаас болж Орос, Хятад, Японы хоорондын зөрчил цаашид улам хурцдах нь дамжиггүй гэж үзэж байсан нь илэрхий. Өөрөөр хэлбэл, энэ гурван гүрэний Монголыг нэг ёсондоо булаацалдах тэмцэл дуусаагүй гэж дүгнэж байжээ.

Түүний сацуу, АНУ-ыг Монголд тагнуулуудаа илгээсэн гэж гадаадынхан мэдээлж байв. Тухайлбал, Нийслэл Хүрээнд байсан норвег худалдаачдыг Бээжин дахь Америкийн дипломат төлөөлөгчийн газрын тагнуулууд мөн бололтой гэж Өргөөгөөс ерөнхий консул нь 1912 оны 3 дугаар сард төвдөө мэдээлсэн баримт ²² бий. Бас, Францын « Le Temps » сонины 1912 оны 4 дүгээр сарын дугаарт « Тройцковск » хотод Америкийн Төлөөлөгчийн газрын хоёр нууц туршуул сууж

²⁰ Ibid.

²¹ Ibid

²² “Архив внешней политики России”, фонд миссия в Пекине, дело № 316, л. 209.

байна"²³ гэсэн мэдээ нийтлэгджээ. Эдгээр мэдээний үнэн магадыг одоо олоход төвөгтэй нь мэдээж.

Юутай ч, бидний эдүгээ төсөөлж байгаагаар, америкчуудын алс хэтийн төлөвлөгөө нь, Хятадыг цэрэг, эдийн засгийн хувьд хүчирхэг гүрэн болсон цагт Орос, Хятад хоёр мөргөлдөх нь зайлшгүй гэж мөрөөдөн, монголын асуудлыг шийдвэрлэлгүй хойш тавихад оршиж байжээ хэмээн дүгнүүштэй. Үүнийг Рокхилл, Моррисон нарын бичиглэл ч нутлаж байнам. Тэр үед цэрэг-эдийн засгийн салбарт жингийн туухайг Оросын тал илүүтэй дарж байсан тул энэ хоёр гүрний хооронд дайн гарах нь ашиггүй гэж Хятадыг дэмжиж байсан Америк үзэж байсан болов уу. Ийм ч учраас ерөнхийлөгч Вильсон, Монголын эсрэг цэрэг дайны ямар ч алхам хийхгүй байхыг Юань-Шикайд зөвлөж байсан баримт буй²⁴.

Ийм сэдлэг Богд хаант Монгол улс тусгаар тогтнолоо зарласан цагаас Америкийн улс төрийн бодлоготон, дипломатуудын толгойд орсон байж болзошгүй. АНУ болон өрнөдийн томоохон гүрнүүдийн хэвлэлийн мэдээ сэлт, тэнд хэвлэгдсэн ном товхимлоос ч үзэхэд АНУ-ын ийм байр суурь БНМАУ байгуулагдсаны дараа ч, тухайлбал ЗХУ, БНХАУ-ын харилцаа эрс муудсан 60-аад онд /өнгөрсөн зууны/ мэдэгдэж байсан түүхтэй. Үүнд, Америкийн нэрт сэтгүүлч Сольсбери Монголд зочилсны дүнд бүтээсэн номдоо, Зөвлөлт, Хятадын дайн зайлшгүй, гэхдээ Монголын нутагт дайтна хэмээн таамаглаж байсныг дурдаж болох юм.

Тэр үеийн Япон, Франц, Англи, Герман, АНУ-ын засгийн газруудын Монголын талаар нийцэж байсан бодлого, байр суурийг энд үл өгүүлэн, зөвхөн тусгайлан авч үзэхэд л их гүрэн бүр уг асуудалд өөр өөрийнхөөрөө хандаж байсан онцлогтой юм. АНУ-ын тухайд гэвэл Гадаад Монголд эдийн засаг, худалдааны ашиг сонирхолтойгоос гадна Орос, Хятадын харилцаанд монголын асуудал цаашид хэрхэн тавигдахын тухайд алс хэтийн улс төрийн зорилго агуулж байжээ гэж үзэж болно. Чухамхүү үүнд их гүрний бодлогынх нь мөн чанар илэрч билээ.

²³ "Le Temps", 5 avril 1912.

²⁴ "Минь-ли-бао", № 906, 1913 г. –В жур. : Дальний Восток, № 21, 25 мая 1913 г. – Иркутск, 1913, стр. 1-2.

Abstract: It is not my intention here to talk about the ten commonalities in policy or politics of the Governments of Japan, France, the United Kingdom, Germany and United States vis-à-vis Mongolia. However, case study indicates each great power took individualistic position on the subject matter. More specifically, the United States vested economic and commercial interests in Outer Mongolia, while Russia and China sought political gains in their relationship with Mongolia. It is precisely here lies the substance of the great power politics.

Ном зүй

1. Archive du MAE de la France, N.S. Pays : Chine, № du volume 80
2. Die Grosse Politik, bd. 32, № 11997
3. Архив внешней политики России, фонд миссия в Пекине, дело № 316
4. Documents diplomatiques français, Troisième série, t. I
5. Международные отношения в эпоху империализма, серия III, т. VII, ч. I
6. Underdown. M. Aspects of Mongolian History, 1901-1915
7. Царская Россия и Монголия в 1913-1914 гг., "Красный архив", 1929, т. VI
8. Сладковский М.И. Китай и Англия. —М., 1980
9. Ширендыб Б. История Монгольской народной революции. Сокр. Перевод с монг. М., 1971
10. Matin, 29 décembre 1911
11. New-York Times, December 1, 1912
12. Le Temps, 5 avril 1912. Минь-ли-бао № 906, 1913 г. —В жур. : Дальний Восток, № 21, 25 мая 1913 г. 13. Иркутск, 1913